



“МИАТ” ТӨХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@afccp.gov.mn,

Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.09.23 № 01/1610

танай _____-ны № _____-г

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай компаниас зарласан “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал” МИАТ/20240103122 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Хаан даатгал” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-д “2023 оны жилийн эцсийн байдлаар нийт нөөц сан /Орлогод тооцоогүй хураамжийн нөөц + Учирсан боловч мэдэгдээгүй ХНС + Мэдсэн боловч төлөөгүй ХНС + Учирч болзошгүй ХНС + Тусгай нөөц сан/ нь төсөвт өртгөөс багагүй байх. /Санхүүгийн зохицуулах хорооны албан бичгээр ирүүлэх/” гэж заасан байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Даатгалын салбарын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан”-гийн мэдээллээс үзэхэд 2023 оны жилийн эцсийн байдлаар 15 аж ахуй эрхлэгч ердийн даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулсан байх бөгөөд үүнээс 8 аж ахуй эрхлэгчийн нөөц сангийн хэмжээ ТШЗ 19.1-д тавигдсан шаардлагыг хангахаар дүгнэгдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд...хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.” гэж, 16 дугаар зүйлийн 16.1-д “Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.” гэж тус тус заасан байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-д “2023 оны жилийн эцсийн байдлаар нийт нөөц сан /Орлогод тооцоогүй хураамжийн нөөц + Учирсан боловч мэдэгдээгүй ХНС + Мэдсэн боловч төлөөгүй ХНС + Учирч болзошгүй ХНС + Тусгай нөөц сан/ нь төсөвт өртгөөс багагүй байх.” гэж заасан шалгуур үзүүлэлт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу хариуцлагатай байх зарчмыг баримтлан боловсруулсан гэж үзэж байна.

0003887

Иймд тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН